



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №06

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 03-р сарын 01-16 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 03-р сарын 01-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1, H3N8, H7N9, H9N2, H6N1, H10N8, H7N4, H5N6, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.


Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 03-р сарын 01-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Аргентин, АНУ, Камбоджи, Чили, БНХАУ, Колумб, Эквадор, Герман, Хондурас, Япон, Мексик, Непал, Сенегал, Швед, Тайвань, Уругвай, зэрэг 16 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 105 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу).

Хун, галуу, нугас, тогоруу, шонхор, цахлай зэрэг нүүдлийн усны, махчин нийт 31 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 4 зүйлд өвчлөл бүртгэгдсэн байна.

Нүүдлийн шувуудыг агнадаг эсвэл өвчилсөн болон үхсэн шувуудаар хооллодог махчин амьтад ихэвчлэн өвчилдөг. Нийт 24 зүйл махчин амьтад, тэжээвэр болон зэрлэг гахай, 4 зүйл далай тэнгэсийн хөхтөн амьтад шувууны томуугийн *clade* 2.3.4.4b хэв шинжээр өвчилж байсан (зураг 1). Газар нутгийн хэмжээнд хамгийн өргөн тархсан хөхтөн амьтан болох үнэг нь илүү өртсөн байна.

2022 (АНУ, Испани) болон 2023 онд (Перу) хөхтөн амьтад олноор үхсэн 3 тохиолдол бүртгэгдсэн ба хөхтөн амьтнаас хөхтөн амьтдад халдвар дамжсан байх магадлалтай гэж үзсэн.



Зураг 1. Олон улсад 2016 оноос хойш хөхтөн амьтдын дунд бүртгэгдсэн тохиолдлууд

Эх сурвалж: <https://www.efsa.europa.eu/en/publications>

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5	Аргентин	Нугас, тахианы аж ахуй	27
H5N1	Камбоджи	Зэрлэг шувууд	1
H5, H5N1	Чили	Хотон, цахлай, Хун, <i>Enhydra lutris</i> , тахианы аж ахуй	21
H5N1	Колумб	Тахианы аж ахуй, хотон	6
H5N1	Эквадор	Тахианы аж ахуй, хотон	3
H5N1	Герман	Тахианы аж ахуй, хотон	3
H5N1	Хондурас	Хотон <i>Pelecanus occidentalis</i>	1
H5N1	Япон	Хэрээ, Гангар хун, Хар тогоруу, Манхин галуу, Эгэл шонхор, Сар шувуу	20
H5N1	Мексик	Тахианы аж ахуй	8
H5N1	Непал	Тахианы аж ахуй	2
H5N1	Сенегал	Хараалай, цахлай	2
H5N1	Швед	Галуу <i>Branta leucopsis</i>	1
H5N1	Тайвань	Тахианы аж ахуй	1
-	Уругвай	Тахианы аж ахуй	2
H5N1	АНУ	Өмхий хүрэн	1
H5N1	АНУ	Пума <i>Puma concolor</i>	1
H5N1	АНУ	Элбэнх	1

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>



Зураг 2. 2023 оны 03-р сарын 01-16 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

ЗӨСҮТ- Шувууны томуу хариуцсан баг